



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХУРААНГУЙ ТАЙЛАН¹

**АУДИТЫН СЭДЭВ: “НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД
САНХҮҮЖҮҮЛСЭН АВТО ЗАМЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

АУДИТЫН КОД: ЭУГ-2024/44/-ШТА-ГА

Аудитыг хэрэгжүүлсэн хугацаа: 2024.10.10-2024.12.05

**Улаанбаатар хот
2024 он**

¹ Хураангуй тайлан нь үр дүнгийн мэдээллийг зорилтот хэрэглэгчид, харилцагч талуудад хураангуй байдлаар хүргэн тэдгээрийн санал бодлыг хүлээн авч, цаашид аудитын үр дүнг сайжруулахад чиглэгдэнэ.

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 10 дугаар сарын 03 -ны өдрийн А/65 дугаар тушаалын дагуу аудитыг хийж гүйцэтгэв.

Бид аудитыг гүйцэтгэх явцад дараах гол асуудалд анхаарлаа хандуулсан:

“Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2024 оны эхний хагас жилд санхүүжүүлсэн авто замын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, зөвлөмж боловсруулан, дүн, дүгнэлтийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх..

Аудитыг төрийн аудитын стандарт, тавигдах бусад шаардлага, арга зүйн дагуу гүйцэтгэж хамарсан хүрээний асуудлыг дэлгэрэнгүй тайланд тусгасан болно.

Бид энэхүү ажлын үр нөлөөг хангахын тулд дараах хэм хэмжээний акт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг баримталсан:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан Бид аудитын түлхүүр асуудалд түшиглэн гол дүнд үндэслэн дэд зорилтын дагуу дараах дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Нийслэлийн Замын хөгжлийн газар бөгөөд Авто замын тухай хууль тогтоомжийг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, нийслэлийн авто замын сүлжээг төлөвлөх, авто зам, замын байгууламжийн барилга, өргөтгөл шинэчлэлт, засвар, ашиглалт, арчлан хамгаалалтын ажлыг зохион байгуулж байна.

НИТХ-ын 2023 оны 122 дугаар тогтоолоор Нийслэлийн 2024 оны төсвийг батлахдаа, Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 89,234.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй авто зам, замын байгууламж, засвар арчлалтын 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, нийт 77,860.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, 2024 оны 88, 105 дугаар тогтоолоор тодотгол хийсэн боловч төсөвт өртөг болон санхүүжих дүн өөрчлөгдлөөгүй байна.

Тус баталсан төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 11 удаагийн захирамжаар 235 багц төсөл, арга хэмжээ болгон задалсан байна.

Төсөл, арга хэмжээ нь батлагдсан зураг төсөв, холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу гүйцэтгэгдсэн эсэхэд дүгнэлт гаргуулах шинжээчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зарласан боловч уг тендерт оролцогч ирээгүй болно.

Нийслэлийн Дотоод аудитын алба нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулсан “Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамж”-ын дагуу 2023 он, 2024 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан зорилтот түвшин түүний зарцуулалт, дээд шатны төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг түүний зарцуулалт, тусгай сангуудын төлөвлөлт зарцуулалт, хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалтад дотоод аудитын хяналт шалгалтыг 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс хийж эхэлсэн байна.

Авлигатай тэмцэх газар зарим авто зам, замын хэсэгчилсэн засвартай холбоотой томоохон ажлын баримтуудыг 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс хүлээн авч хяналт шалгалтын ажлыг эхлүүлжээ.

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлсэн 61 авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн төсөл, арга хэмжээтэй холбогдох худалдан авах ажиллагааны баримтуудыг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэс 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс тус тус шалгаж байна.

АУДИТЫН ДҮН ба ГОЛ АСУУДАЛ**Бүлэг 1: НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД БҮРЭН НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА**

1.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцүүлсэн хэдий ч холбогдох зардлын тооцоолол хийгээгүй байна.

1.2. Нийслэлийн Замын хөгжлийн газраас 2023 оны 05/2000 дугаартай албан бичгээр Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгах “Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалт”-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлжээ.

1.3. НИТХ-ын 2023 оны “Нийслэлийн 2024 оны төсөв батлах тухай” 122 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар Замын сангийн хөрөнгө оруулалтаар 77,860.2 сая төгрөгийн 24 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж, төсвийн тодотголоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, санхүүжүүлэх дүнд өөрчлөлт ороогүй байна.

1.4. Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүй төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

 Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, Авто замын тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна

1.5. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-т заасан “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3. “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасныг тус тус зөрчиж байна.

1.6. Төсөл арга хэмжээний нэр, байршлыг тодорхой заагаагүй төсвийг баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.3.4-т заасан “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасантай нийцэхгүй байна.

1.7. Замын сангийн хөрөнгийг зориулалт бус чиглэлд буюу замын байгууламж, зөвлөх үйлчилгээний төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8-д “Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж байна. Тухайлбал:

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн авто замын байгууламж, арчлалт, засварын ажил зэрэг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гарч буй эрсдэл-1

Тогтоогдсон эрсдэлийн түвшин “Өндөр” буюу хөрөнгө оруулалтын удирдлага, хяналт сул, энэ нөхцөл байдал нь төлөвлөлтийн шаардлагын зарчим, төсвийн үр нөлөөтэй байдлыг хангахааргүй, зохисгүй зарцуулалт нь төлөвлөлтийн эцсийн зорилго хангагдахгүйд хүргэх эрсдэлтэй байна.

Бүлэг 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙГ ЗОХИХ ХУГАЦААНД ГАРГААГҮЙ НЬ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧИХӨД ХҮРГЭСЭН БАЙНА

2.1. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг НЗД нь 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш шилжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасныг зөрчиж байна. Тухайлбал:

- Богд уулын арын авто замын баруун хэсгийн засвар шинэчлэлт ажил нь 2,613.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 6 дугаар сарын 3-ны өдөр;
- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар шинэчлэлт (Дөлгөөн нуурын уулзвараас Өлзий төвийн уулзвар хүртэл) нь 1,248.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 7 дугаар сарын 22-ны өдөр;
- Хувьсгалчдын гудамжны авто замын засвар шинэчлэлт (Тасганы овооны уулзвараас Зурагтын эцэс хүртэлх) нь 3,800.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 8 дугаар сарын 28-ны өдөр;
- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил нь 4 багцад 2,194.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 6 дугаар сарын 18-ны өдөр;
- Багануур дүүргийн авто замын засвар нь 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 7 дугаар сарын 23-ны өдөр;
- Багахангай дүүргийн авто замын засвар нь 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 6 дугаар сарын 6-ны өдөр;
- Налайх дүүргийн авто замын засварын ажил нь 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 6 дугаар сарын 6-ны өдөр;
- Инженер, техникийн ажилчдыг салбарын чиглэлээр мэргэшүүлэх, бэлтгэх, дадлагажуулах нь 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 7 дугаар сарын 1-ний өдөр тус тус эрхийг шилжүүлсэн байна.

2.2. Зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт 2024 оны 3 дугаар сард ирснээс шалтгаалан худалдан авах ажиллагаа оройтсон байна

2.3. НИТХ-ын 122 дугаар тогтоолд 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 88 дугаар тогтоолд өөрчлөлт ороогүй бөгөөд 9 дүгээр сарын 24-ний өдрийн 105 дугаар тогтоолд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,503.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 71,889.6 сая төгрөг болсон боловч Нарны хорооллоос Нарны зам руу төмөр зам дээгүүр гарсан гүүрэн гарц (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг) төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлсэн захирамжийг НЗХГ-т ирүүлээгүй байна.

2.4. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх авто зам, замын засвар, шинэчлэлтийн 19 төсөл, арга хэмжээ нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамжаар 69,386.5 сая төгрөгийн 55 төсөл, арга хэмжээ болж задарсан байна.

2.5. Нийслэлийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэхээр төлөвлөж НИТХ-ын тогтоолд тусгагдсан, Засаг даргын захирамжаар тус газарт эрх шилжсэн боловч хийгдээгүй дараах ажлууд байна. Үүнд:

- “Гүүр, хоолой, туннелийн засварын ажил” нь 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд үнэлгээний хороог 2024 оны 1 дүгээр сарын 15-нд байгуулж тендерийг 5 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендерийн материал ирүүлээгүй;
- “Нийтийн тээврийн хэрэгслийн тусгай эгнээний өнгөт хучилт” ажил нь 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд бондын хөрөнгө оруулалтаар хийгдсэн

зам засварын ажлыг хийж дууссаны дараа тэмдэглэгээг хийх тул тендерийг зарлаагүй, хойшлуулсан;

- Гадна тойруугийн авто замаас 149 дүгээр сургууль хүртэлх холбоос зам (Чингэлтэй дүүрэг) нь 1,430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд ажлын зураг төсөл нь хийгдээгүй тул тендер зарлаагүй байна.

2.6. Түүнчлэн Засаг даргын захирамж гараагүй дараах ажлууд байгаад анхаарах шаардлагатай байна. Тухайлбал: Энэ нь нэг талаас нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжих үндэслэлтэй, зорилгод нийцсэн байдлаар хэрэгжүүлэх, хэрэгцээ шаардлагын үнэлгээг арга хэмжээ бүрээр хийж ажиллах бодит шаардлага байгааг харуулж байна.

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчиход ээлтэй орчин бүрдүүлэх ажил” нь 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй;
- “Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажил” нь 1500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй;
- “Магадалшгүй ажил” нь 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тус тус ажлууд байна.

2.7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-д “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” гэсэн заалтын дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулж дуусаагүй 7,430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагаа зарлаагүй 4,430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ;
- Шаардлагад нийцсэн тендерийн материал ирүүлээгүй 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ;
- Засаг даргын захирамж гараагүй 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ байна.

2.8. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш тендерийн ажлыг 57-68 хоногоор хугацаа алдаж зарласан нь захиалагч ТАХ-ны техникийн тодорхойлолтыг хоцроож ирүүлснээс шалтгаалсан байна. Тухайлбал:

- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 багц задарсан ажлуудын үнэлгээний хороог 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан боловч захиалагчаас техникийн тодорхойлолт, тоо хэмжээг 3 дугаар сарын 21-ний өдөр ирүүлснээс тендерийг 4 дүгээр сарын 17-ны өдөр нээсэн;
- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын ажлын 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үнэлгээний хороог 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулж, захиалагчаас техникийн тодорхойлолт, тоо хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр ирүүлснээс тендерийг 4 дүгээр сарын 22-ны өдөр нээсэн байна;

2.9. Хөрөнгө оруулалтын шинж чанартай худалдан авах ажиллагааны үйл явцыг тогтмол давтамжтай цаг хугацаанд нь үнэлж байх, зохистой удирдлага-хяналтын тогтолцоо үйлчлээгүй гэж үзэхээр байна.

✚ **Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ-нд захиалагчийн хяналтыг батлагдсан төсөвт өртгийн дагуу хэрэгжүүлээгүй байна.**

2.10. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний төсөвт өртгийн магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй байхад НЗХГ нь авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг олгож, захиалагчийн хяналтыг батлагдсан төсөвт өртгийн дагуу хэрэгжүүлээгүй нь тухайн нөхцөл байдалд арвилан хэмнэлтийн зарчим баримтлахгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэхээр байна.

- Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Квадровэй ХХК-ийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн ажил дууссан тухай №29/24 тоот алба бичиг ирсэн ч, тухайн ажлын төсөвт өртгийн 232/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 06 дугаар сарын 20 өдөр баталгаажсан;
- Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /хан-уул дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Баткубик ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн ажил дууссан тухай №133/2024 тоот албан бичиг ирсэн ч, тухайн ажлын төсөвт өртгийн 256/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 07 дугаар сарын 03 өдөр баталгаажсан байна.

2.11. Зарим ажлуудын магадлалтын дүгнэлт баталгаажаагүй байхад авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, зөвшөөрөл олгосон нь Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах авах журмын 2.2.-т “Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

✚ **Нийслэлийн авто замын хөгжлийн газар нь төсвийн хөрөнгөөр авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх, засвар арчлалт, ашиглалт, арчлалт хамгаалалтын ажлыг зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэгтэй боловч Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд магадлалаар баталгаажсан хяналтын төсөвгүйгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үе шатны санхүүжилтийг олгосон байна**

2.12. НИТХ-ын 2023 оны 122 дугаар тогтоолоор Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийг шинээр барих болон шинэчлэлт хийхэд 13,648.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээнд 3,473.7 сая төгрөг, авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын 70,386.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээнд 70,386.5 сая төгрөг, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, зураг төсөл, магадалшгүй ажлын 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээнд 2,000.0 сая төгрөг, Нийслэлийн авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн сангийн хөгжүүлэлтийн 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд 2,000.0 сая төгрөг нийт 77,860.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ын жагсаалт (сая төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2024 онд олгох санхүүжилт
1	Авто зам, замын байгууламжийг шинээр барих болон шинэчлэлт	4	13,648.1	3,473.7
2	Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт	15	70,386.5	70,386.5
3	Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, зураг төсөл, магадалшгүй ажил	4	2,000.0	2,000.0
4	Нийслэлийн авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн сангийн хөгжүүлэлт	1	3,200.0	2,000.0
	ДҮН	24	89,234.6	77,860.2

2.13. Тус төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг НИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 122 дугаар тогтоолоор авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас 44,788.4 сая төгрөг, авто зам ашигласны төлбөрөөс 21,313.4 сая төгрөг, авто зам дээрх хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчлийн торгуулийн орлогоос 33,000.0 сая төгрөг нийт 99,101.8 сая төгрөг бүрдүүлэхээр баталсныг, “Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 88 дугаар тогтоолоор авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас 44,788.4 сая төгрөг, авто зам ашигласны төлбөрөөс 22,279.4 сая төгрөг, авто зам дээрх хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчлийн торгуулийн орлогоос 24,300.0 сая төгрөг нийт 91,367.8 сая төгрөг байхаар тогтоон 7,734.0 сая төгрөгөөр бууруулан тодотгон баталсан боловч гүйцэтгэлд хяналт тавьдаггүй.

Хүснэгт 2. Төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн жагсаалт (сая төг)

Д/д	Орлогын нэр төрөл	НИТХ-н 2023 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан	НИТХ-н 2024 оны 88 дугаар тогтоолоор тодотгосон	Өсөлт/бууралт
1	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	44,788.4	44,788.4	-
2	Авто зам ашигласны төлбөр	21,313.4	22,279.4	966.0
3	Авто зам дээрх хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчлийн торгуулийн орлого	33,000.0	24,300.0	8,700.0
	ДҮН	99,101.8	91,367.8	7,734.0

2.14. Гүйцэтгэлээр авто зам, замын байгууламж шинээр барих болон шинэчлэлт хийх 2 төсөл арга хэмжээнд 2,483.4 сая төгрөг, хотын гол болон туслах гудамж, замуудын арчлалт, засварын 11 төсөл, арга хэмжээнд 7,615.7 сая төгрөг, хотын гол болон туслах гудамж замуудын засвар, шинэчлэлт болон авто зам, замын байгууламжийг шинээр барих 8 төсөл, арга хэмжээнд 15,096.3 сая төгрөг, Буян Налайх худалдааны төвийн гэрлэн дохиотой уулзвараас Уурхайчдын 14 дүгээр гудамж хүртэл авто замын шинэчлэлийн ажилд 694.0 сая төгрөг нийт 22 төсөл арга хэмжээнд 25,889.4 сая төгрөгийн үе шатны санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 3. Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны эхний хагас жилд олгосон санхүүжилт (сая төг)

Д/д	Хөрөнгийн эх үүсвэр	2023/122 дугаар тогтоолоор				Гүйцэтгэл				
		ТАХ тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих		2024 онд олгосон			Барьцаа хөрөнгийн дансанд	
				Дүн	Хувиар	ТАХ тоо	Дүн	Хувиар	ТАХ тоо	Дүн
1	Нийслэлийн замын сан	65	89,234.6	77,860.2	87	22	25,889.4	33	3	617.8
	Нийт	65	89,234.6	77,860.2	87	22	25,889.4	33	3	617.8

2.15. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд магадлалаар баталгаажсан хяналтын төсөвгүйгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үе шатны санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 4.1.26-д "техник, технологийн хяналт" гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Квадровэй ХХК-ийн 2024 оны 6 дугаар сарын

04-ний өдрийн ажил дууссан тухай №29/24 тоот алба бичиг ирсэн ч, тухайн ажлын төсөвт өртгийн 232/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан, 2024 оны 6 дугаар сарын 14-нд 2,666.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон;

- Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Хан-уул дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Баткубик ХХК-ийн 2024 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн ажил дууссан тухай №133/2024 тоот албан бичиг ирсэн ч, тухайн ажлын төсөвт өртгийн 256/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр баталгаажсан, 2024 оны 6 дугаар сарын 04-нд 881.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

✚ **Нийслэлийн авто замын хөгжлийн газар нь авто зам, замын байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах, нийслэлийн өмчид бүртгүүлэх үндсэн чиг үүрэгтэй боловч бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг эзэмшигч байгууллагад бүртгүүлэх хүсэлтийг НӨХГ-т хүргүүлээгүй, эзэмшигчийн тайлан баланст бүртгээгүй байна**

2.16. Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд, он дамжин хэрэгжиж дууссан 8,377.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Дэнжийн 1000-ын Цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэлх туслах замын өргөтгөл нь бүрэн хэрэгжиж дууссан боловч эзэмшигчид шилжүүлэх хүсэлтийг НӨХГ-т хүргүүлээгүй, хөрөнгө бүртгэлгүй байна.

2.17. Энэ нь Нийслэлийн ИТХ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.1 "Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл хөтөлбөр, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг тухайн төсөл хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

2.18. Авто замын тухай хуулийн 12.1.6-д заасны дагуу "Нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах, талаар журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж НИТХ-аар батлуулах, хэрэгжүүлэх," гэсэн хуулийн зохицуулалт хэрэгжээгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн авто замын байгууламж, арчлалт, засварын ажил зэрэг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гарч буй эрсдэл-2

Тогтоогдсон эрсдэлийн түвшин "Өндөр" буюу хуульд заасан хугацааны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд магадлалаар баталгаажсан хяналтын төсөвгүйгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үе шатны санхүүжилтийг олгож байгаа энэ нөхцөл байдал нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн үе шатны хяналтын шаардлагын зарчим, төсвийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг хангахааргүй, зохисгүй зарцуулалт нь хөрөнгө оруулалтын эцсийн зорилго хангаагдахгүйд хүргэх эрсдэлтэй байна.

Бүлэг 3. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ КОМИСС ХУУЛЬ, ЖУРМЫГ БҮРЭН МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

3.1. НЗХГ нь Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ажлыг хүлээн авахдаа Нийслэлийн Замын хөгжлийн газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/34 дүгээр тушаалаар баталсан бүрэлдэхүүнээр комисс ажиллуулсан нь "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 4.3-д "Захиалагч хүсэлтийг хүлээн

авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Ажлын хэсэг ажиллуулах эсэх шийдвэр гаргана.” гэж заасантай нийцэхгүй байна.

✚ **Бүрэн хэрэгжиж дууссан замуудын хайс, тоноглолыг эзэмшигч байгууллагад бүртгүүлэх хүсэлтийг НӨХГ-т хүргүүлж, эзэмшигчийн тайлан балансд бүртгүүлээгүй байна.**

3.2. Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 оноос он дамжин хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээ бүрэн дууссан боловч баримтыг бүрдүүлж, эзэмшигч хуулийн этгээдэд бүртгүүлэх хүсэлтийг НӨХГ-т хүргүүлээгүй, хөрөнгө бүртгэлгүй байна. Энэ нь НИТХТ-ын 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-ын 1.3.1-д “хуулийн этгээдийн хүсэлт, 1.3.6-д мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт”, 1.4.3-д “ашиглалт, их болон урсгал засварын талаархи мэдээлэл”, 1.10-д “эд хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг холбогдох бичиг баримтын хамт Нийслэлийн Өмчийн харилцааны газарт ирүүлэх үүрэг хүлээнэ” гэж заасаныг хэрэгжүүлээгүй байна.

✚ **Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн авто замын засвар, арчлалтын ажилд тавих хяналтыг Авто замын тухай хуулийн 22.6.-д “Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна**

3.3. Захиалагч нь хяналтыг хэрэгжүүлэхдээ “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4, 5.5, 5.6, 5.8, 5.9, 5.15 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Авто замын хуучин хашлага /бродюр/ буулгаж, шинээр суулгах явцад буулгасан явган хүний замыг нөхөн сэргээгүй байна.
- Авто замын хашлага буюу бродюрын арын тулц, бетон, манаасыг дутуу гүйцэтгүүлсэн.
- Авто замын хашлага /бродюр/-ны гагнаасны ажлыг дутуу гүйцэтгэсэн.

Тухайлбал: Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Баянзүрх дүүргийн Намьянжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлтийг талбар дээр очиж үзэхэд авто замын хуучин хашлага /бродюр/ буулгаж, шинээр суулгах явцад буулгасан явган хүний замыг нөхөн сэргээгүй байна.



Мөн Баянзүрх дүүргийн Амгалангийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлтийг газар дээр нь очиж үзэхэд авто замын дэргэдэх ус зайлуулах хоолойны тагууд эвдэрч, гэмтсэн байна.



Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн авто замын байгууламж, арчлалт, засварын ажил зэрэг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гарч буй эрсдэл-3

Тогтоогдсон эрсдэлийн түвшин “Дунд” буюу хэрэгжсэн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авч эзэмшигчид шилжүүлэх шийдвэр гаргуулаагүй нь хөрөнгө оруулалтын цаашдын ашиглалт, хамгаалалтад сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл байдал үүсгэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, ажлын удирдамжид заасан зорилт, хамрах хүрээгээр хязгаарлан нотлох баримтыг цуглуулан судалж, аудитын арга зүйн дагуу хийсэн дүн шинжилгээ, эрх бүхий албан тушаалтантай хийсэн ярилцлагын дүнд үндэслэн аудитын тайланг бэлтгэсэн.

Аудитын хураангуй тайланд аудитын дүнгийн чухал, ач холбогдолтой хэсгийг тусган, үйлдвэрийн удирдлагын багийн цаашид авч хэрэгжүүлэх асуудлаар холбогдох арга хэмжээний саналыг боловсруулан тайлангийн зөвлөмж хэсэгт харуулсан болно.

Бид аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг санал болгосноо аудитын тайлангаар баталгаажуулсан бөгөөд цаашид санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар холбоотой талуудтай хамтран ажиллахыг санал болгосон.

Дүгнэлт, зөвлөмжийн хураангуй дараах байдалтай байна. Үүнд:

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авто замын тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүй, хууль тогтоомжид бүрэн нийцүүлж төлөвлөөгүй байна.
- Нийслэлийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэхдээ нийслэлийн Засаг дарга захирамжуудаа зохих хугацааг баримтлаагүй гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байна.

- Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг баталгаажсан хяналтын төсөвт өртгийн дагуу хэрэгжүүлээгүй байна.
- Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд магадлалаар баталгаажсан хяналтын төсөвгүйгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үе шатны санхүүжилтийг олгосон байна.
- Хэрэгжсэн төсөл арга хэмжээг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгуулах шийдвэрийг гаргуулж, бүртгүүлээгүйгээс шалтгаалж хөрөнгө эзэнгүйдэх, арчлалт хамгаалалт алдагдах эрсдэлтэй байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

- **Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид**
 - Нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах, талаар журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж НИТХ-аар батлуулж, хэрэгжүүлж ажиллах;
 - Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Авто замын тухай хуультай нийцүүлэн төлөвлөж, худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулах;
- **Нийслэлийн Замын хөгжлийн газарт**
 - Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төсвийг магадлалаар баталгаажуулж, захиалагчийн хяналтыг сайжруулан, зохисгүй зарцуулалтаас сэргийлж ажиллах.
 - Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнийг хууль, журамд заасан хугацаанд тухай бүр байгуулж, ажиллуулах.